

ХЯНАЛТЫН ХОРОО

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ӨРГӨДЛИЙН ТАЙЛАН БА ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ УЛС

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ТӨСӨЛ (P118109) болон УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ – НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)
ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1 (БАГАНУУРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙН
ӨРГӨТГӨЛИЙН СУДАЛГАА) болон ГҮНИЙ УСНЫ УДИРДЛАГЫГ
БЭХЖҮҮЛЭХ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3

2018 оны 7-р сарын 23

ТАЙЛБАР: Энэхүү орчуулга нь Англи эхээс нь орчуулсан. Ямарваа нэг зөрүүтэй илэрхийлэл байх аваас Англи эхийг баримтлана. Энэ баримт бичгийн Англи хувилбар нь цорын ганц албан ёсны хувилбар болно.

Хяналтын хороо

Хяналт шалгалт явуулах өргөдөлд гаргасан тайлан ба зөвлөмж

**Монгол Улс: Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109)
болон Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - Нэмэлт санхүүжилт (P145439)
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг 1 (Багануурын нүүрсний
уурхайн өргөтгөлийн дэд төсөл) болон Гүний усны удирдлагыг бэхжүүлэх
бүрэлдэхүүн хэсэг 3**

А. Удиртгал

1. Хяналтын хороо (“Хороо” гэх) нь 2018 оны 4-р сарын 2-нд Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) болон Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - Нэмэлт санхүүжилт (P145439) (цаашид “МИНИС” эсхүл “Төсөл” гэх)-ийн санхүүжүүлж буй үйл ажиллагаанаас үүдэх болзошгүй хор уршгийн талаар Хяналт, шалгалт явуулах хоёр Өргөдөл хүлээн авсан.
2. Нэг Өргөдлийг нь (“эхний Өргөдөл”) хоёр төрийн бус байгууллагаас ирүүлсний нэг нь Оюу Толгойн Хяналт ТББ, нөгөө нь Улаанбаатар хотын Багануур дүүргийн иргэдийн нэрийн өмнөөс өргөдөл гаргалцсан нэрээ нууцлахыг хүссэн орон нутгийн төрийн бус байгууллага. Өргөдөл гаргагчид нь Төслийн санхүүжүүлж буй Багануурын уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (ХНҮ)-нээс хүний эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), уур амьсгалын өөрчлөлт зэрэгтэй холбоотой хор уршиг учирч болзошгүй ба ийнхүү хор уршиг дагуулах хүчин зүйлсэд мэдээлэл өгөх, олон нийтээр хэлэлцүүлэх явдал дутмаг байгааг дурджээ.
3. Удаах Өргөдөл (“хоёрдугаар Өргөдөл”) нь Оюу Толгойн Хяналт ТББ, мөн өөрийн нэрийг нууцлахыг хүссэн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын оршин суугчдаас ирсэн. Үүнд, Төслөөс санхүүжүүлж буй усны менежментийн төлөвлөгөө гаргах болон сав газрын захиргаа (СГЗ) байгуулах ажил нь нутгийн иргэд өөрсдийнхөө уламжлалт газар нутаг, усны эх үүсвэрүүдээ ашиглах боломжгүй болох, байгаль орчинд нөлөөлөх зэрэг болзошгүй хор уршигтай дээр мэдээллийг ил болгох болон олон нийтээр хэлэлцүүлэх дутагдалтай байгаа гэдгийг дурджээ.
4. Хороо нь Өргөдлүүдийг 2018 оны 5-р сарын 11-нд бүртгэж, Захирлуудын зөвлөл (“Зөвлөл”) болон Банкны Удирдлага (“Удирдлага”)-д мэдэгдсэн. Банк нь уг хоёр Өргөдөл нь нэг Төсөлтэй холбоотой тул хамтад нь хэрэгсэх шийдвэр гаргасан. Удирдлага өөрийн Хариуг 2018 оны 6-р сарын 13-нд ирүүлсэн.

В. Төсөл

5. МИНИС төсөл нь 2011 оны 5-р сарын 10-нд Дэлхийн Банкны Захирлуудын Зөвлөлөөс батлагдаж, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн эх үүсвэр бүхий 25 сая

ам.доллартай тэнцэх хөрөнгөөр санхүүжигдэж буй техникийн туслалцааны төсөл юм.¹ 2014 онд Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлагийн итгэлцлийн сангаас 4.2 сая ам.доллартай тэнцэх хөрөнгийг баталж, хамгааллын шинэ бодлогуудыг Төсөлд хамааруулахаар бүтцийн өөрчлөлт хийсэн.² Төслийн хөгжлийн зорилтууд нь “санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхай, эцсийн шатны боловсруулалтад үзүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг бэлтгэж, хэрэгжүүлэх дотоодын чадавхыг бэхжүүлэх” болно.³ МИНИС төсөлд хамрагдах Шүрэнгийн усан цахилгаан станц болон Орхон говийн усны тохируулга хийх дэд төслүүдийн Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ, түүнтэй холбогдох эрчим хүч, усан хангамжийн судалгаануудтай холбоотой үйл ажиллагааг явуулах үүднээс Төсөлд 2016⁴ болон 2017 онд тус тус бүтцийн өөрчлөлт хийж, төсөл хаах хугацааг 2019 оны 9-р сарын 30 болгож сунгасан.⁵

6. МИНИС төсөл нь дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй, үүнд: (1) дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих, (2) чадавхыг сайжруулах, мэдлэг олгох (3) газрын доорх усны менежментийг бэхжүүлэх, болон (4) төслийн удирдлага.⁶ Өргөдлүүд нь нэгдүгээр болон гуравдугаар бүрэлдэхүүн хэсгүүдэд хамааралтай юм. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Төсөл нь урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ болоод байгаль орчны үнэлгээний судалгаа гэх зэрэг Монгол Улсын уул уурхайн салбарыг дэмжих зорилготой санал болгосон дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон бусад олон үнэлгээ боловсруулах ажлыг санхүүжүүлж буй юм.⁷ Гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг нь ГДУММН, СГЗ болон Сав газрын зөвлөл (СГЗӨ)-үүд байгуулах гэх зэргээр Монгол Улсын говийн бүсэд гүний усны менежментийн төлөвлөгөө, үнэлгээний судалгаа хийх, гүний усны нөөцийг удирдах орон нутгийн чадавхыг бэхжүүлэх ажлыг дэмжиж буй юм.⁸ Сангийн яам (СЯ) нь Төслийн хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд СЯ дор Төсөл удирдах нэгж (ТУН)-ийг байгуулсан болно.⁹

7. Төсөл нь Байгаль орчны А ангилалд хамаарах бөгөөд хамгааллын дараах бодлогуудыг үүнд мөрдүүлж буй болно: Байгаль орчны үнэлгээ (ОР/ВР 4.01), Онгон байгаль (ОР/ВР 4.04), Биет соёлын өв (ОР/ВР 4.11), Албадан нүүлгэн шилжүүлэлт (ОР/ВР 4.12), Далангийн аюулгүй байдал (ОР/ВР 4.37) болон Олон улсын усан замын төсөл (ОР/ВР 7.50).¹⁰

С. Өргөдлүүд

8. Эхний өргөдөлд байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөлөл, ЖСХ болон уур амьсгалын өөрчлөлт гэх зэрэг Төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санхүүжүүлж байгаа

¹ Төслийн үнэлгээний баримт бичиг, 2011 оны 4-р сарын 7.

² Нэмэлт санхүүжилтийн зорилгоор Австралийн Олон улсын хөгжлийн агентлагийн санал болгосон буцалтгүй тусламжийн талаарх төслийн баримт бичиг болон бүтцийн өөрчлөлтийн баримт бичиг, 2014 оны 3-р сарын 18.

³ Төслийн үнэлгээний баримт бичиг, 2011 оны 4-р сарын 7, х. 4.

⁴ Санал болгосон төслийн бүтцийн өөрчлөлтийн баримт бичиг, 2017 оны 9-р сарын 27, хэсэг. 2.

⁵ Дээрхтэй адил, хэсэг. 9.

⁶ Төслийн үнэлгээний баримт бичиг, April 7, 2011, p. 5.

⁷ Дээрхтэй адил, х. 25-27.

⁸ Нэмэлт санхүүжилтийн зорилгоор Австралийн Олон улсын хөгжлийн агентлагийн санал болгосон буцалтгүй тусламжийн талаарх төслийн баримт бичиг болон бүтцийн өөрчлөлтийн баримт бичиг, 2014 оны 3-р сарын 18, х. 4.

⁹ Төслийн үнэлгээний баримт бичиг, х. 8.

¹⁰ Нэмэлт санхүүжилтийн зорилгоор Австралийн Олон улсын хөгжлийн агентлагийн санал болгосон буцалтгүй тусламжийн талаарх төслийн баримт бичиг болон бүтцийн өөрчлөлтийн баримт бичиг, 2014 оны 3-р сарын 18, х. 1.

Багануурын нүүрсний уурхайн ТЭЗҮ болон ХНҮ-нээс болзошгүй хор хохирол учирна гэж үзсэн.

9. **Эрүүл мэндийн нөлөөлөл.** Өргөдөл гаргагчид нь нүүрсний нэмэлт олборлолт болон Төслөөс санхүүжихгүй боловч тэдний үзэж буйгаар дагалдах байгууламж гэх 700 МВ-ын Багануурын шинэ дулааны цахилгаан станц (ДЦС)-аас үүдэлтэй агаарын бохирдол болон түүнээс улбаатай эрүүл мэндийн нөлөөллийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Тэд нүүрсний нэмэлт олборлолт болоод цахилгаан станц нь Улаанбаатар хотын ихээр бохирдсон агаарыг нэмж бохирдуулах, чингэснээр ялангуяа хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг эрсдэлд оруулна гэж үзэж байна.

10. **Жендэрт суурилсан хүчирхийлэл.** Гадаадын ажиллах хүчин ихээр шилжин ирснээр ЖСХ болон хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэл нэмэгдэнэ гэж мэдүүлсэн. Өргөдөл гаргагчдын мэдүүлснээр Багануурын уурхайн өргөтгөл болон ДЦС-д ажиллахаар 3,000-5,000 ажилчин шилжин ирэх бөгөөд тэд охид, эмэгтэйчүүдэд учрах болзошгүй эрсдлийн талаар санаа зовниж буй юм. Тэд “ХНҮ-ний хамрах хүрээнд жендэрийн нөлөөллийг үнэлэх талаар дурдаагүй бөгөөд бууруулах арга хэмжээг санал болгох магадлал бага байна” гэж мэдүүлсэн.

11. **Уур амьсгалын өөрчлөлт.** Төслөөс үүдэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө гарахыг Өргөдөл гаргагчид мэдүүлсэн бөгөөд энэхүү нүүрсний төсөл болон дагалдах байгууламжийг орлох хувилбаруудыг ОР 4.01-ийн дагуу судалсан эсэхийг Хяналтын хорооноос хянахыг хүсэмжилсэн.

12. Өргөдөл гаргагчид нь уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ болон ХНҮ гэх зэрэг Төслөөс санхүүжүүлж буй судалгааны чанараас үүдэн хор хохирол гарах болзошгүй бөгөөд судалгаануудтай холбоотой хэлэлцүүлэг хийх, мэдээллийг ил болгох нь дутмаг байгаа нь мөн л хор хохирол дагуулах болзошгүй гэж үзэж байна.

13. **Судалгааны чанар.** Өргөдөл гаргагчид нь тэдний тодотгосноор 2015 оны “стандарт хангахгүй” ХНҮ-ний төслөөс хойш олгосон хугацааг харгалзан үзвэл удахгүй бэлэн болох ХНҮ-ний чанарт санаа зовж буйгаа илэрхийлсэн. Түүнчлэн тэд уг судалгааг хийж буй зөвлөхүүдийн техникийн чадвар, туршлагад эргэлзэж буй юм.

14. **Мэдээллийг нийтэд ил болгох ба хэлэлцүүлэх.** Өргөдөл гаргагчид нь мэдээллийг нийтэд ил болгох, хэлэлцүүлэх нь дутагдалтай байна гэж мэдүүлсэн. Хэдийгээр 2016 онд хэлэлцүүлэг явуулсан боловч, хариултын хүснэгтийг одоо болтол гаргаагүй, нүүрсний уурхайн өргөтгөл, түүнтэй холбоотой байгууламжийн болзошгүй нөлөөлөл эсхүл нөлөөллийг бууруулах санал болгож буй арга хэмжээний талаар нөлөөлөлд өртөх иргэдтэй хэлэлцээгүй гэж мэдүүлсэн. Түүнчлэн ил болгосон цорын ганц баримт бичиг нь 2014 оны ХНҮ-ний Ажлын даалгавар (АД) болох бөгөөд түүнийгээ Монгол хэлээр, орон нутгийн иргэдэд ойлгохуйц байдлаар ил болгоогүй гэж тэд мэдүүлсэн. Өргөдөл гаргагчид үүнийг “дүр исгэсэн зөвлөгөөн” болоод МИНИС төсөл “а) нөлөөлөлд өртөж болох иргэд болоод эмзэг бүлгийн хүн амын бүлгийн төлөөлөл бүхий холбогдох оролцогч талуудын оролцоог хангах, мөн б) болзошгүй сөрөг нөлөөллийн мэдээллийг ил болгож, түүнийг бууруулах арга хэмжээний талаар хэлэлцэх...” үүргээ биелүүлж чадаагүй бүтэлгүйтсэн гэж томъёолсон.

15. Хоёрдугаар Өргөдөлд уламжлалт газар болон усны эх үүсвэр ашиглах боломж алдагдах, эрүүл мэндийн асуудлууд болоод байгаль орчны нөлөөлөл гэх зэрэг Төслийн гуравдугаар бүрэлдэхүүн хэсгээс санхүүжүүлж буй Алтайн-Өвөр говийн нутагт Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө (УННМТ) болон СГЗ-г байгуулснаас үүдэн болзошгүй хор хохирол учирч буй гэж мэдүүлсэн.

16. **Газар, усны нөөцийг ашиглах боломж алдагдах.** Өргөдөл гаргагчид нь Говь нутагт газар болон уламжлалт усны эх үүсвэр ашиглах боломж алдагдсан гэж үзэж байна. 2001 оноос нүүрсний уурхайнуудын үйл ажиллагаа эхэлснээс хойш 30 гол, горхи болон булаг шанд ширгэсэн бөгөөд одоо байгаа зургаан уурхай болон шинээр төлөвлөгдсөн уурхайнуудаас хуримтлагдах нөлөөлөл гүний усанд гарахаас санаа зовниж буй юм. Уламжлалт мал маллагаа, фермерийн аж ахуй эрхэлж буй 60 өрхийн амьжиргаанд энэ бүгдээс үүдэн гарах нөлөөллөөс тэд эмээж байна. Тэд үүнийг “нүүлгэн шилжүүлэлт эсхүл усны эх үүсвэрээ алдсаны нөхөн төлбөргүйгээр газар булаах үйлдэл” гэж томъёолсон байна.

17. **Эрүүл мэндийн нөлөөлөл.** Өргөдөл гаргагчид нь ферм болон бэлчээрийн ургамал бохирдсоноор эрүүл мэндийн асуудал дагуулна гэж санаа зовинож буйгаа илэрхийлсэн. Тэд “уурхайн орчим амьдарч буй хүн амын дунд өвчлөл нэмэгдэх, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх” талаар дурдсан болно.

18. **Байгаль орчны нөлөөлөл.** 2018 оны 4-р сарын 17-нд Хороотой хийсэн уулзалтын үеэр нүүрсний уурхайнууд Гурвантэс нутгийн усны нөөцөд нөлөөлж буйгаас ховордсон ан амьтанд үзүүлэх сөрөг нөлөө байгаа ба нэн ялангуяа Өмнөговийн Тостын нурууны ирвэсний төрөл зүйлийн талаар Өргөдөл гаргагчид цохон дурдсан. Тэд 2018 оны 4-р сарын 26-нд холбогдох нэмэлт мэдээлэл цахим шуудангаар ирүүлсэн.

19. Өргөдөл гаргагчид нь “СГЗ-ны усны нөөцийн зохистой менежментийн төлөвлөгөө болоод нүүрсний уурхайн эрчимтэй үйл ажиллагаанаас уламжлалт усны нөөцөд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл, хэлэлцүүлэг дутмаг байгаа нь бидний усны нөөцөд газар дээр нь шууд хор хохирол учруулж байна” гэж үзэж буй юм.

20. **Судалгааны чанар.** Тэд “техникийн шаардлага хангахгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй компаниудыг сонгон шалгаруулсны улмаас усны сав газрын үнэлгээ, сав газрын менежментийн төлөвлөгөө чанаргүй хийгдсэнээр орон нутгийн иргэдийн гадаргын болон хөрсний усны нөөцийг тэр чигт нь үгүй хийхэд хүргэж болзошгүй” гэж үзэж буй юм.

21. **Мэдээллийг нийтэд ил болгох ба хэлэлцүүлэх.** Өргөдөл гаргагчдын үзэж буйгаар тайлангууд нь нууцлалын зэрэгтэй тул мэдээллийг ил болгохгүй байна. Иймээс, одоогийн болон ирээдүйд төлөвлөсөн нүүрсний уурхайнуудын усны чанар, олдцод үзүүлэх нөлөөлөл болоод СГЗ нь усны нөөцийг хэрхэн удирдаж буй талаарх мэдээлэл иргэдэд байхгүй байна.

22. Өргөдөлд Дэлхийн Банкны Захирлуудын зөвлөлд хандсан дараах зөвлөмжүүдийг тусгасан болно, үүнд: (i) “МИНИС-ийн төслүүдийн шийдвэр гаргах засаглалыг хянах;” (ii) “Говийн иргэд хангалттай ундны устай байх” болон “аж үйлдвэрээс ус болон экосистемийг хамгаалах” нөхцөлөөр хангахын тулд [.....] хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх; мөн (iii) “усны хэрэглээний талаар холбогдох олон улсын стандартын дагуу шийдвэр гаргахын өмнө үнэлгээний тайланг ил болгож, хэлэлцүүлэг явуулах” тус тус орсон болно.

D. Удирдлагын хариу

23. Удирдлагын хариуг доор хураангуйлсан болно. Хариуг бүрэн эхээр энэхүү Тайлангийн Хавсралт II-т тусгасан болно.

24. Удирдлага нь өөрийн Хариундаа “Өргөдөл гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд нь Банкны зүгээс МИНИС төслийн хүрээнд санхүүжүүлж буй судалгаа эсхүл чадавхыг бэхжүүлэх ажлаас үүдэх хор уршиг биш, харин зөвхөн санал болгож буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын барилгын ажил, ашиглалт болон/эсхүл эдгээр нь зүйл ёсоороо хэрэгжихгүйгээс үүдэж болзошгүй хор уршигтай холбоотой байна” гэж мэдүүлсэн. Тус Банк нь МИНИС төслийн хүрээнд судлагдаж буй аливаа хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд оролцоогүй бөгөөд санхүүжүүлэх шийдвэр гаргаагүй гэсэн тайлбарыг Удирдлагын зүгээс өгч байна.¹¹

25. Удирдлага нь “тус Банкнаас олгож буй техникийн зөвлөмжийг холбогдох бүхий л Банкны бодлоготой нийцүүлэх нь чухал” гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд үүнд түүний бэлтгэл, дүгнэлт болон зөвлөмжийг гаргахад мөрдсөн үйл явц мөн хамаарна гэлээ.¹² ХНУ, УННМТ болон МИНИС төслөөс санхүүжүүлж буй бусад судалгаанууд нь Банкны бодлогын хүрээнд хамааралтай мэдээлэлийг ил болгох болон хэлэлцүүлэх шаардлагуудыг хангаж буй гэж Удирдлага мэдүүлсэн.

26. Банк төсөлтэй холбоотой өөрийн бодлогоо зөрчиж буй гэх Өргөдөл гаргагчдын байр суурьтай санал нэгдэхгүй байгаагаа Удирдлага мэдэгдсэн. МИНИС төслөөс санхүүжүүлж буй судалгаа болон чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ нь ирээдүйн хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах оновчтой бөгөөд ил тод суурийг тавих замаар тогтвортой хөгжлийг дэмжиж байгаа бөгөөд нийгэм, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, гүний усны менежментийн чиглэлээрх чадавхын асуудлыг шийдэж буй гэж тухайн Хариуд тайлбарласан болно.¹³

27. **Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн судалгаа.** Удирдлага нь “уг ТЭЗҮ-г нийтэд ил болгож, хэлэлцүүлсэн байдал болон түүний дүгнэлт, зөвлөмж нь тус Банкны бодлогын холбогдох шаардлагуудыг хангасан” гэж үзэж байна.¹⁴ Удирдлагын үзэж буйгаар ОР/ВР 4.01-ын[ийн] хүрээнд мэдээлэл ил болгох болон хэлэлцүүлэх шаардлага нь ТЭЗҮ-д хамаарахгүй юм. Удирдлага нь үүнд Зээлдэгчийн зүгээс нууцлалын зэрэгтэй гэж үзэх мэдээлэл орсон бөгөөд түүнийг “Банкны Мэдээлэл авах бодлогын хэсэг 2(г)-д заасанчлан “гишүүн орон болон гуравдагч этгээдийн нууцлалын зэрэгтэйгээр олгосон мэдээлэл хэмээн тооцно” гэж дүгнэсэн.¹⁵

28. Удирдлага нь Багануурын нүүрсний уурхайн ХНУ-г боловсруулж байгаа бөгөөд 2018 оны эцсээр хэлэлцэж, эцэслэнэ гэж тэмдэглэсэн. Удирдлага нь Өргөдөл гаргагчдын

¹¹ Удирдлагын хариу, х.8.

¹² Дээрхтэй адил.

¹³ Дээрхтэй адил, х.8.

¹⁴ Дээрхтэй адил, р.9.

¹⁵ Дээрхтэй адил.

дэвшүүлсэн асуудлуудыг ХНҮ-ний хүрээнд судлахдаа ДЦС уурхайн орчим байрладаг бас нүүрс нийлүүлэх тохиролцоонд хүрсэн тул энэхүү судалгаанд хамруулна гэж дурдсан болно. Удирдлага нь уурхайн өргөтгөлийн үр дүнд нүүрс нэмж боловсруулах, тээвэрлэх болон шатаахтай холбоотой байгаль орчин болон нийгмийн нөлөөллийг ХНҮ-ний хүрээнд судална гэж тайлбарласан.¹⁶ Эцэслэн гарсан ХНҮ нь уурхайн өргөтгөлийн (үүнийг МИНИС төслийн хүрээнд санхүүжүүлэхгүй) ТЭЗҮ болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ)-г шинэчлэн боловсруулахад ашиглах мэдээллээр хангана.

29. **Агаарын бохирдол.** Удирдлага нь тус Банк ДЦС-тай холбоотой ямар нэгэн дэмжлэг үзүүлэхгүй байгаа бөгөөд бохирдолтой холбоотой аливаа болзошгүй хор уршиг нь “зөвхөн ДЦС-аас үүдэх боломжтой болохоос биш Төслөөс санхүүжүүлж буй судалгаануудаас үүдэх боломжгүй” гэж тэмдэглэсэн.¹⁷ Тиймээс Удирдлагын үзэж буйгаар тэрхүү нөлөөллүүдийг ДЦС-ын БОННҮ-нд шинжлэн судлах нь зүйтэй юм. ДЦС-аас ялгарах болзошгүй бохирдлыг агаарын урсгалаар хүлээн авах нь байгаль орчны эрсдэлүүдийн нэг учир ХНҮ-ний хүрээнд үнэлгээ хийнэ гэж Удирдлага нь тайлбарлаж байна.

30. **Ажиллах хүч шилжин ирэхтэй холбоотой эрсдэлүүд.** Удирдлага нь өөрийн өгсөн Хариундаа ажиллах хүч шилжин ирэхээс үүдэн охид, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлүүдийг нухацтай авч үзэж байгаагаа мэдүүлсэн. Удирдлага нь МИНИС төсөл зөвхөн техникийн туслалцаа үзүүлж буй тул ажиллах хүч шилжин ирэх асуудал нь Төсөлтэй холбоогүй гэж үзэж байна. МИНИС төсөл нь ДЦС-ад дэмжлэг үзүүлдэггүй боловч барилгын ажлын үеэр ихээхэн хэмжээний ажиллах хүч шилжин ирэхээс үүдэх нийгмийн нөлөөллийн талаар зовниж буйгаа МУЗГ-тай хэлэлцсэн гэж Удирдлага тайлбарлаж байна.¹⁸ Түүнчлэн ажиллах хүч шилжин ирэх асуудлуудыг ХНҮ-нд багтаан судлахаа Удирдлага мэдэгдлээ.

31. **Өмнө говийн бүс дэх усны менежмент.** Удирдлага нь “МИНИС төсөл нь ус нэн ховор Өмнө говийн бүсэд гүний усны менежментийн чиглэлээр ихээхэн хувь нэмэр оруулсан” гэж мэдэгдлээ.¹⁹ Удирдлагын мэдүүлснээр МИНИС төсөл нь гурван СГЗ-г байгуулж, СГЗӨ-ийн уулзалтуудыг дэмжиж, улмаар гүний усны менежментын институцийн арга барилыг сайжруулсан. Төсөл нь техникийн мэдээллээр хангах, энэхүү үйл явцын хүрээнд илүү олон оролцогч талуудыг хамруулах замаар усны хомсхон нөөцийн талаарх институцийн шийдвэр гаргалтыг бэхжүүлэхэд тус нэмэр үзүүлсэн.

32. УННМТ-нүүд нь хэт шавхалтаас үүдэх усны хомсдолд орохоос сэргийлэхийн тулд суурин газруудын ундны усны хэрэгцээ гэх зэрэг сав газрын түвшин дэх хэрэглээнд ашиглах боломжтой бүх усны нөөцийн тооцоог хамарч буй гэж Удирдлага тайлбарлаж байна. Уг төлөвлөгөөнүүд нь бүс нутаг дахь одоогийн болон ирээдүйн усны нөөцийн байдал, усны нөөцийн менежменттэй холбоотой өөр олон асуудалд дүн шинжилгээ хийнэ гэдгийг Удирдлагаас мэдэгдлээ. Төлөвлөгөөнүүдийг олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагатай гэдгийг Удирдлага нь Зээлдэгчид зөвлөсөн²⁰ бөгөөд 2018 оны эцэс гэхэд УННМТ-нүүдийг хэлэлцэж, эцэслэнэ гэж тооцоолж байна.

¹⁶ Дээрхтэй адил, х. 10.

¹⁷ Дээрхтэй адил, х.11.

¹⁸ Дээрхтэй адил.

¹⁹ Дээрхтэй адил, х.12

²⁰ Дээрхтэй адил, х.13.

33. Төсөл нь гүний устай холбоотой “олон тооны жижиг техникийн судалгааг” санхүүжүүлж байгаа бөгөөд техникийн судалгааг хамаардаггүй мэдээллийг ил болгох шаардлага ОР/ВР 4.01-ийн дагуу “Төслийн БОНМХ-нд гүний усны судалгаа, чанарын үнэлгээ, түүвэр судалгаа, зураг, аргачлал болон судалгааны төлөвлөгөөг хамгааллын хэрэгсэл ашиглах эсхүл хэлэлцүүлэх болон олон нийтэд ил болгох шаардлагагүй гэж тодорхой заасан болно” гэж Удирдлага тэмдэглэсэн.²¹ Түүнчлэн Удирдлага нь хэд хэдэн судалгааг Банкны Мэдээллийн хүртээмжийн бодлогын хэсэг 2(g)-т заасанчлан нийтэд ил болгох заалтад хамаарахгүй гэж үзэж байна.

34. Удирдлага нь гүний усны дата мэдээллийг нууцад тооцдог бусад харилцагч улс орны адилаар ил болгоогүй хэд хэдэн тайлангууд нь Монгол Улсын хуулийн дагуу нууцлалын зэрэглэлтэй гэж үзэж байгааг тэмдэглэсэн.²² Удирдлага нь Монгол Улсын Засгийн газарт аль болох их мэдээллийг ил болгохыг уриалсан гэж тайлбарлаж буй юм.

Е. Өргөдлийн дагуу хийсэн Хорооны хяналт, менежментийн хариу, шалгалт

35. Хорооны гишүүн Ян Маттсон болон Хорооны захиргааны хэлтсийн ажилтан Тамара Милштайн нь Монгол Улсад 2018 оны 7-р сарын 1-7-ны хооронд ажилласан. Уг баг нь Багануурт хүрэлцэн очиж Өргөдөл гаргагчид, болзошгүй нөлөөлөлд өртсөн иргэд, Багануурын уурхайн захиргаа болон орон нутгийн засаг захиргааны төлөөлөлтэй уулзсан. Улаанбаатар хотод уг баг Дэлхийн Банкны Суурин төлөөлөгчийн газрын ажилтнууд, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, МИНИС-ийн ТУН-н төлөөлөлтэй уулзаж, Даланзадгадад байралдаг СГЗ-ын төлөөлөлтэй мөн уулзсан. Даланзадгадад СГЗӨ-ийн гишүүдтэй тус баг уулзсан болно. Гурвантэс суманд уг баг нь Өргөдөл гаргагчид болон болзошгүй нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдтэй уулзсан.

36. Дээр дурдсан оролцогч талууд өөрийн бодол, мэдээлэл болон нарийн мэдлэгийг хуваалцсанд Хороо талархаж байна. Монгол Улсын Засгийн газар өөрийн албан тушаалтнуудтай уулзах боломжоор хангасанд Хороо талархаж байна. Хороо нь мөн Өргөдөл гаргагчид, нөлөөлөлд өртсөн иргэд, Улаанбаатар хот дахь Дэлхийн Банкны Суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудад цаг заваа гарган эдгээр асуудлуудыг хэлэлцэж, холбогдох мэдээллээр хангасанд талархал илэрхийлж байна. Логистикийн зохицуулалт хийхэд үнэлж баршгүй туслалцаа үзүүлсэн Монгол дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудад онцгойлон талархал илэрхийлж байна.

Е.1 Техникийн нийцтэй байдал

37. Өргөдлийн техникийн нийцтэй байдал нь 1999 оны Тодруулгын 9-р хэсэгт заасан шалгуурын дагуу үнэлэгддэг. Уг Өргөдөл нь доор дурдсан зургаан техникийн нийцтэй байдлын шалгуурыг хангаж байна гэж Хороо үзсэн болно:

38. Шалгуур (а): “Нөлөөлөлд өртсөн тал нь зээлдэгчийн нутаг дэвсгэрт оршин суудаг, ижил бэрхшээл, ашиг сонирхолтой 2 буюу түүнээс дээш хүнээс бүрдэнэ.” Хороо нь Өргөдөл гаргагчдад МИНИС төслөөс үүдэх үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутагт амьдарч буй нутгийн иргэд орсон болохыг баталгаажуулсан.

²¹ Дээрхтэй адил, х.14.

²² Дээрхтэй адил, Хавсралт 2, х. 25.

39. Шалгуур (b): “Өргөдөл нь Банк өөрийн үйл ажиллагааны бодлого, журмыг ноцтой зөрчиж байгааг, эсвэл хүсэлт гаргагчид материалын сөрөг нөлөө үзүүлж байгаа эсхүл үзүүлэх магадлалтайг нотлох ёстой.” Хэрэв судалгааны сэдэв болох хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжвэл МИНИС төслөөс санхүүжүүлж буй үнэлгээний судалгаанууд нь Өргөдөл гаргагчдад ноцтой хор нөлөө учруулж болно гэж Өргөдөл гаргагчид үзэж буй юм. Тэд үнэлгээний судалгааны чанар учир дутагдалтай, олон нийтээр хэлэлцүүлэх байдал дутагдалтай буюу хангалтгүй гэж үзэж байна. Тэд эдгээр дутагдалтай байдал нь байгаль орчин, эрүүл мэнд болон нийгмийн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй гэж маргаж буй юм. Эдгээр дутагдалууд нь Банкны үйл ажиллагааны бодлого, журмын зөрчил болж байна гэж Өргөдлүүдэд мэдүүлжээ. Тиймээс Хороо нь энэхүү шалгуур хангагдсан гэж үзэж байна.

40. Шалгуур (c): “Өргөдөлд дэвшүүлсэн асуудлыг Удирдлагын анхааралд хүргүүлсэн авч Өргөдөл гаргагчдын үзэж буйгаар Удирдлагын зүгээс Банкны бодлого, журмыг даган мөрдсөн эсхүл дагаж мөрдөхөөр арга хэмжээ аван ажиллаж буйг хангалттай нотолсон хариу өгөөгүй гэдгийг мэдүүлсэн аж”. Өргөдөл гаргагчид эл Өргөдлүүдийг гаргахын өмнө дэвшүүлсэн асуудлуудаа Удирдлагын анхааралд хүргэсэн болохыг Хороо баталгаажуулсан учир энэ шалгуур мөн хангагдсан.

41. Шалгуур (d): “Асуудал нь худалдан авах ажиллагаатай холбоогүй байх.” Хороо нь түүнд ирүүлсэн гомдлыг хянан үзэж, худалдан авах ажиллагаатай холбоогүй гэдгийг тогтоосон тул энэхүү шалгуурыг хангасан гэж үзэж байна.

42. Шалгуур (e): “Холбогдох зээл нь хаагдаагүй эсвэл ихэнх нь зарцуулагдаагүй байх”. Өргөдлүүдийг хүлээн авах үед Төслийн хөрөнгийн 74 хувь нь зарцуулагдсан байсан. Тиймээс энэхүү шалгуур хангагдсан болно.

43. Шалгуур (f): “Хороо тухайн асуудлын талаар өмнө нь дүгнэлт гаргаж байгаагүй юм уу, гаргаж байсан бол, өмнөх хүсэлт гаргах үед ил болоогүй нөхцөл байдал эсхүл шинэ баримтын талаар энэхүү хүсэлтэд дурдсан байх.” Хороо нь энэхүү Хүсэлтэд хамарсан асуудлаар урьд өмнө нь зөвлөмж гаргаж байгаагүй тул энэ шалгуурыг хангасан гэж үзэж байна.

Е.2. Хорооноос өгсөн зөвлөмжтэй холбоотой түүний дүгнэлт

44. Хороо нь өөрийн зөвлөмжийг Захирлуудын зөвлөлд гаргахдаа дараахыг Үйл ажиллагааны журмын дагуу авч үздэг болно. Үүнд: Өргөдөлд дурдсан хор уршиг болон төслийн хооронд магадлал бүхий шалтгаант холбоо байгаа эсэх; дурдсан хор уршиг болон Банкны өөрийн үйл ажиллагааны бодлого, журмын болзошгүй зөрчил нь ноцтой байх; Удирдлага нь тухайн асуудлыг зохих ёсоор авч үзсэн эсхүл зөрчил гаргаснаа хүлээн зөвшөөрч, Өргөдөл гаргагчдын гомдлыг шийдвэрлэхэд арга хэмжээ авах талаар мэдэгдэл хийсэн эсэх тус тус болно. Хороо нь гомдолд дурдсан хор уршиг болон түүний үр дагавартай холбоотой урьдчилсан ажиглалтаа доор өгүүлж буй бөгөөд ингэснээрээ Банк өөрийн бодлого, журмаа дагаж мөрдсөн эсэх болоод түүнээс үүдэлтэй аливаа ноцтой үр дагаврыг эцсийн байдлаар үнэлсэн гэсэн үг биш юм.

Анхны хүсэлт: Багануурын уурхайн өргөтгөл

45. Хороо нь томилгоот ажлынхаа хүрээнд уурхайн өргөтгөл болон ДЦС-аас үүдэлтэй болзошгүй нөлөөллийн талаар зовниж буйгаа илэрхийлсэн Багануур дахь нутгийн иргэдийн төлөөлөл, орон нутгийн төрийн бус байгууллагуудтай уулзсан. МИНИС төслөөс санхүүжүүлж буй ХНҮ болон ТЭЗҮ нь Багануурын уурхайн өргөтгөлд төвлөрсөн боловч Өргөдөл гаргагчид нь ДЦС-ыг уурхайд хамааралтай байгууламж гэж үзэж буй юм. Тэд, уурхай нь эл нутагт тодорхой эдийн засгийн үр өгөөж авч ирсэн ба ялангуяа эрэгтэйчүүдэд ажлын байр буй болгосон хэмээн тайлбарласан. Гэсэн хэдий ч агаарын бохирдол, тоосжилт гэх мэт байгаль орчин, эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл амссан гэж буй бөгөөд уурхайн өргөтгөл болон ДЦС нөхцөл байдлыг улам хүндрүүлнэ гэж санаа зовниж буй юм. Тэд ажиллах хүч шилжин ирэх болон нүүлгэн шилжүүлэлтээс нутгийн иргэдэд үзүүлэх хор уршгийн талаар мөн санаа зовнисон байсан.

Багануурын уурхайн өргөтгөлийн үнэлгээ

46. **Байгаль орчин ба эрүүл мэндийн нөлөөлөл.** Багануурын иргэдийн дунд зүрх судасны болон амьсгалын замын өвчлөл өндөр байгааг нутгийн иргэд тайлбарласан. Тэд уурхайн өргөтгөлөөс үүдэн нутгийн иргэдийн эрүүл мэндэд учрах нэмэлт нөлөөллийн талаар мэдэхийг хүсэж байна. Түүнчлэн тэд уурхайгаас үүдэх ураны цацрагийн түвшин болон түүнтэй холбоотой эрүүл мэндийн нөлөөллийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн.

47. Уурхай нь бүс нутаг дахь усны чанар болон хүртээмжид нөлөөлж байгааг мэдүүлсэн ба Хятадын нутагруу урсдаг хил дамнасан гол болох Хэрлэн голын сав газарт уурхайн өргөтгөлийн үзүүлэх нөлөөний талаар тэд санаа зовж буйгаа Хороонд илэрхийлсэн. Тэдний хэлж буйгаар уурхай нь ойр орчмын гол болон гүнээс ус хэрэглэдэг. Уурхайн өргөтгөлөөс үүдэх нэмэлт нөлөөлөл нь нутгийн иргэдийн эрүүл мэнд болон амьжиргаанд нөлөөлнө гэж тэд итгэж буй юм.

48. **Ажиллах хүч шилжин ирэх болон нийгмийн нөлөөлөл.** ДЦС-ын барилгын ажлын үеэр гадаадаас ажиллах хүч шилжин ирэхээс үүдэх болзошгүй нөлөөллийн талаар санаа зовниж буйгаа нутгийн иргэд Хороонд илэрхийлсэн. ЖСХ гарах, биеэ үнэлэх болон хүн худалдаалах гэмт хэрэг гэх мэт жендэрийн болзошгүй нөлөөллөөс тэд эмээж буйгаа илэрхийлсэн. Түүнчлэн тэд гадаадын ажилчид орон нутгийн үйлчилгээнд нэмэлт дарамт үүсгэнэ хэмээн санаа зовниж буйгаа илэрхийлсэн.

49. ДЦС дээр мянга мянган гадаад ажилчид ажиллах тооцоо бүхий баримт бичиг үзсэн гэж нутгийн иргэд тайлбарласан боловч Хороонд орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнуудаас өгсөн мэдээллээр тэрхүү тооцоо шинэчлэгдэж, ДЦС-ыг барих болон ашиглах үед дээд тал нь нэг дор 400 гадаад ажилчин ажиллуулах төлөвлөгөөтэй байна. Түүнчлэн Хороо нь гадаад ажилчдын бааз барьж байсныг ажигласан болно.

50. **Албадан нүүлгэн шилжүүлэлт.** Хороо нь уурхайн одоогийн үйл ажиллагаатай ойр болоод лицензийн талбайд амьдардаг нутгийн иргэдтэй уулзсан бөгөөд тэдний мэдүүлснээр уурхайн төлөвлөгөөт өргөтгөлөөс үүдэн нүүх шаардлагатай болсныг нь орон нутгийн засаг захиргаа саяхан тэдэнд мэдэгдсэн гэв. Тэдний хэлж буйгаар тухайн газарт үндсэндээ мал аж ахуй эрхэлж амьжиргаагаа залгуулдаг нийт 30 өрх байдаг аж. Түүнчлэн өөрийн газар дээр

одоогоор амьдардаггүй газар өмчлөгчид байгаа бөгөөд тэд уурхайн өргөтгөлийн нөлөөлөлд мөн өртөхөөр байгаа гэж Хороонд мэдэгдсэн. Нутгийн иргэд тэднийг хэзээ нүүлгэх эсхүл хэр их хэмжээний нөхөн төлбөр өгөх талаар мэдээлэл дутмаг байгаа гэж хэлсэн.

51. **Хороотой хийсэн уулзалтын үеэр орон нутгийн засаг захиргаа болон Багануурын уурхайн компанийн төлөөлөгчид нутгийн иргэдийг нүүлгэх нь тодорхой боловч хугацаа болон нөхөн төлбөрийг хэн хариуцах нь тодорхойгүй байгаа гэдэг мэдээллийг баталгаажуулав.** Нутгийн иргэд нь уурхайн лицензийн талбайд амьдарч байгаа хэдий ч орон нутгийн засаг захиргаанаас тэдэнд 60 жилийн турш газар ашиглах гэрчилгээ олгосон гэж тайлбарласан. Одоог хүртэл нүүлгэн шилжүүлэлтийн ямар нэг төлөвлөгөө боловсруулаагүй байгаа гэж Хороонд мэдэгдсэн.

52. **Альтернатив хувилбарын талаарх дүн шинжилгээ.** Судалгааны хүрээнд альтернатив хувилбаруудыг авч үзээгүй, ХНҮ-нд нүүрсийг орлох хувилбар, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг авч үзэх нь зүйтэй гэж Өргөдөл гаргагчид мэдүүлсэн.

53. ХНҮ нь Багануурын уурхайн өргөтгөлийн нөлөөлөл, нөлөөллийг бууруулахад санал болгох арга хэмжээг үнэлэх учиртай бөгөөд альтернатив хувилбаруудыг шинжих ажил нь ХНҮ-н хамрах хүрээнээс гадуур байгааг Хороо ойлгож байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар болон Багануурын ДЦС-ын хооронд байгуулсан концессын гэрээнд ДЦС-ад хэрэглэх нүүрсийг Багануурын уурхайгаас тэргүүн ээлжинд нийлүүлнэ гэж заасан болно.²³²⁴

54. **ХНҮ-ний цар хүрээ ба хугацаа.** Өргөдөл гаргагчид болон нутгийн иргэд Хороотой уулзахдаа ХНҮ-ний холбогдох хэлэлцүүлгүүд хэзээ, ямар процессын дагуу явагдах, ХНҮ хэзээ хийгдэж дуусах нь тодорхойгүй байгаа бөгөөд үйл явц удааширч байгаад цөхөрч буйгаа илэрхийлсэн. Түүнчлэн тэд ХНҮ-нд эрүүл мэнд, жендэрийн нөлөөллийн талаар хангалттай тусгасанд эргэлзэж буйгаа илэрхийлсэн.

55. Хороо нь 2015 онд бэлтгэгдсэн ХНҮ-ний анхны төсөл хангалтгүй гэж дүгнэгдэн, уг ХНҮ-г боловсруулахаар ажиллаж байсан зөвлөхийн гэрээг цуцалсан гэж ойлгож буй. Нарийвчилсан АД-ыг боловсруулж, уг төслийг шинэчлэн боловсруулахаар шинэ зөвлөхийг шалгаруулан авсан. АД-ыг харьцуулбал үнэлгээг шинэчлэхтэй холбоотойгоор зөвлөхүүдийн хийх ажлын цар хүрээ тэлсэн болохыг Хороонд мэдэгдсэн. Хороо нь ХНҮ-ний хамрах хүрээ ихээхэн тэлсэн бөгөөд тэрхүү хүрээнд Хэрлэн голын сав газарт үзүүлэх нөлөөлөл болоод ажиллах хүч шилжин ирэхтэй холбоотой гэх зэрэг ДЦС-тай холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үнэлнэ гэж ойлгож байгаа.

56. Багануурын ХНҮ нь Монгол Улсын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн хүрээнд хийгдэж буй анхны үнэлгээ бөгөөд Удирдлага нь ирээдүйд хийгдэх ийм үнэлгээний загварыг тогтоох, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байсан гэж Хороонд мэдэгдсэн. Эдгээр зорилгуудын дагуу ХНҮ-г боловсруулах ажил хойшлогдсон гэдгийг Удирдлага тайлбарласан.

57. **Багануурын уурхайн өргөтгөл болон ДЦС-ын төслийн статус.** Удирдлага нь өөрийн өгсөн Хариундаа Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хандан уурхайн өргөтгөлийн

²³ Концессын гэрээ, х.22. Дараахаас харна уу: <http://nda.gov.mn/backend/f/rcnv1crjX5.pdf>.

²⁴ Удирдлагын хариу, х.7-г харна уу.

нэмэлт хөрөнгө оруулалтыг зөвхөн ХНҮ болон холбогдох хэлэлцүүлэг эцэс болсны дараа хийх нь зүйтэй гэдгийг дурдсан захидал явуулсан гэж тэмдэглэсэн. Уурхайн компани нь өргөтгөлөө эхлэх боломжтой болохоос өмнө шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилтийг хүлээж буй гэж Хороонд мэдэгдсэн. ДЦС-ын ажилчдын бааз, оффис болон яндангийн барилгын ажил гэх зэрэг зарим нэг бэлтгэл ажил эхэлсэн байхыг Хороо нь томилгоот ажлынхаа үеэр ажигласан. Улсын эрчим хүчний шугам сүлжээний шаардлагад нийцүүлэхийн тулд генераторуудын хүчин чадлыг бууруулах зорилгоор концессын гэрээг хянан үзэж, дахин хэлэлцээр хийж болзошгүй тул ДЦС-ын ажлыг зогсоосон гэж Хороонд мэдэгдсэн.

Мэдээллийг ил болгох, хэлэлцүүлэг хийх

58. Багануурын иргэд ХНҮ-ний хэлэлцүүлэгт уригдаагүй тул оролцоогүй, тиймээс тус үнэлгээний хамрах хүрээ болоод хугацаа, Багануурын уурхайн өргөтгөл болон ДЦС-ын болзошгүй нөлөөллийн талаар бага мэдээлэлтэй байгаа гэж мэдэгдсэн. Түүнчлэн өмнөх хэлэлцүүлгүүдэд 400 хүн оролцсон гэж МИНИС төслөөс тэдэнд мэдэгдсэн боловч тэдгээр уулзалтуудад оролцсон ганц ч хүнтэй тааралдаагүй гэж тэд мэдэгдсэн.

59. Хороо нь ХНҮ-ний АД-ын хэлэлцүүлгүүд 2014 онд болсон гэсэн ойлголттой байна. Түүний дараа ХНҮ-ний төслийг 2015 оны 9-р сард хэлэлцүүлсэн. 2015 онд болсон хэлэлцүүлгүүд чанар муутай байсан учраас 2016 оны 4-р сард дахин хийгдсэн гэдгийг Удирдлага нь хүлээн зөвшөөрч байна.²⁵

60. ХНҮ-ний шинэчилсэн төслийг Банкны зүгээс техникийн чанар хангасан гэж үзсэний дараа 2018 оны намар хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байгаа гэж Удирдлага Хороонд мэдэгдсэн. Удирдлага болон ТУН нь уулзалтууд болохоос 14 хоногийн өмнө урилга болон холбогдох материалуудыг оролцогчдод тараах ба ХНҮ-ний техникийн болон техникийн бус хураангуйг бэлтгэж байгаа гэж баталгаажуулсан. МИНИС-ийн ТУН болон Удирдлага нь Шүрэнгийн усан цахилгаан станц болон Орхон говийн усны тохируулгын төслийн үнэлгээний судалгааны талаарх өмнө гаргасан өргөдөл болон хэлэлцүүлгийн дараа ТУН-ийн хэлэлцүүлэг хийх чадавх нэлээдгүй сайжирсан гэж тайлбарласан.

61. Удирдлага нь өөрийн Хариундаа уурхайн өргөтгөл (Банкнаас санхүүжүүлээгүй)-ийн БОННУ болон ТЭЗҮ-г ХНҮ-ний үр дүнд тулгуурлан шинэчлэгдэнэ гэж мэдэгдсэн. Засгийн газрын төлөөлөл болон Удирдлага нь Багануурын уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ нь олон нийтэд ил болохгүй гэж тайлбарласан. Судалгаанд уурхайн зүгээс ил болгох хүсэлтгүй байгаа санхүүгийн болон эдийн засгийн мэдээлэл агуулагдсан хэдий ч судалгааны техникийн хэсгүүдийг салган нийтэд ил болгох боломжийг судалж байгаа гэж Удирдлагаас Хороонд мэдэгдсэн.

Хоёрдугаар Өргөдөл: Алтайн-Өвөр говийн бүсийн усны менежмент

62. Хороо нь томилгоот ажлынхаа үеэр Засгийн газрын төлөөлөл, МИНИС-ийн ТУН, зөвлөхүүд болон Банкны Удирдлагаас УННМТ болон холбогдох хэлэлцүүлэг, Алтайн-Өвөр говийн бүсийн СГЗ болон СГЗӨ-ийн ажлын талаарх мэдээллийг хүлээн авсан.

²⁵ Дээрхтэй адил, х. 16.

63. Түүнчлэн Хороо нь зургаан нүүрсний уурхайн ойр орчинд үйл ажиллагаа явуулж эхэлснээр уламжлалт амьдралын хэв маяг болон амьжиргаанд хэрхэн сөрөг нөлөө үзүүлж буйг харуулсан Гурвантэс болон түүний ойр орчинд амьдарч буй малчид, фермерүүд болон бусад иргэдтэй уулзсан. Тэдгээрийн дурдсан хор нөлөөнд гадаргын ус хомсдож, гүехэн гүний усны эх үүсвэр багассан, ногоон бэлчээр устсан, нүүрсний тоосжилт болон тэсэлгээний дуу чимээ, чичиргээ орж байна. Нөлөөлөлд өртсөн иргэдийн хэлж буйгаар тэдний амьжиргаа алдагдсан болоод нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн төлбөрийг огт өгөөгүй эсхүл хангалттай өгөөгүй байна. Нутгийн бусад иргэд шинээр байгуулагдаж байгаа (тухайн нутаг дахь долоо дахь уурхай) нүүрсний уурхайгаас амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Уг бүс нутаг нь уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөөс үүдэн бэрхшээл зовлонтой тулгарч байгаа бөгөөд биологийн олон янз байдалд шинэ уурхайнууд сөргөөр нөлөөлж, ирвэс болон мазаалай гэх зэрэг ан амьтны төрөл зүйлийг илүү их аюулд оруулна гэж санаа зовниж байгаагаа иргэд Хороонд илэрхийлсэн.

УННМТ-ний бэлтгэл

64. УННМТ-ний гэрээг 2017 оны 6-р сард байгуулсан болохыг Хороо тэмдэглэж байна. Засгийн газрын гидрологичид сонгон шалгаруулсан зөвлөхүүдийн мэргэжлийн чадваруудын талаар эерэг сэтгэгдэлтэй байгаагаа Хороонд илэрхийлсэн. Гэвч иргэний нийгмийн төлөөллүүд болоод иргэдийн зүгээс зөвлөхүүд биологийн олон янз байдал, экологи, нийгмийн асуудлуудын талаар мэргэжлийн чадвар муутай, ижил төрлийн судалгаа хийж байсан туршлага дутмаг гэж хэлсэн. Удирдлага нь, зөвлөхүүд шаардлагатай чиглэлээр мэргэшсэн хүмүүс хэдий ч өөр хоорондоо харилцан адилгүй байдлаар мэргэшсэн гэх байр сууриа Хороонд илэрхийлсэн.

65. Хорооны уулзсан Өргөдөл гаргагчид болон бусад талууд УННМТ-г боловсруулах ажил хэт удааширч байгаа гэсэн сэтгэгдэлтэй байсан. Одоо байгаа УННМТ-ний төсөл нь дөрөв дэхь төсөл бөгөөд түүнийг 2018 оны эцсээр эцэслэх төлөвлөгөөтэй байгаа гэдгийг Хороо тэмдэглэж байна. Удирдлага нь олон улсын тэргүүн туршлага болсон стандартыг ашиглуулах үүднээс аргачлалын тал дээр удирдамж өгсөн бөгөөд орон нутгийн хүн амын уламжлалт амьжиргаанд чухал гэдэг талаас гадаргын эсхүл гүехэн гүний усны нөөцийг хамруулахыг шаардсан гэж тайлбарласан.

66. Зөвлөхүүд нь тэдэнд тулгарч буй хамгийн том бэрхшээл бол усны бодит дата мэдээлэл олдох боломж гэж Хороонд тайлбарласан. Удирдлага үүнтэй санал нэг байгаа боловч Төслийн үр дүнд дата мэдээллийн олдоц сайжирсан болохыг онцолсон. Бүхий л оролцогч талууд найдвартай усны дата олж авах нь чухал болохыг онцолсон боловч нутгийн иргэд тухайн төлөвлөгөөнүүдийг шинэ уурхайнуудад усны зөвшөөрөл олгох үндэслэл болгон буруугаар ашиглах вий гэж санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Бусад талууд УННМТ нь Монгол Улсын Засгийн газарт устай холбоотой мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ гэж буй бөгөөд энэ нь Төслийн зорилготой нийцэж байна.

67. Засгийн газрын төлөөлөл болон бусад оролцогч талууд нутгийн иргэдтэй хийх хэлэлцүүлгийг өнөөг хүртэл зохион байгуулаагүй байгаа гэж Хороонд мэдэгдсэн. Гэсэн хэдий ч зөвлөхүүд нь орон нутгийн засаг захиргааны төлөөлөл, СГЗ-д болон СГЗӨ-үүдтэй өмнө нь уулзсан байна. Зөвлөхүүд нь хүйсээр задалсан усны хүртээмжийн мэдээлэл, нэг өрхөд ногдох усны хэрэглээ болон усны цэгүүдийн байршлыг хамарсан судалгааг 300-500 өрхийн дунд хийсэн гэж Хороонд мэдэгдсэн. Гэвч Хорооноос уулзсан нутгийн иргэд ийм

судалгааны талаар мэдээлэлгүй байсан. Зарим техникийн мэргэжилтнүүд болон нутгийн иргэд орон нутгийн байгаль орчинтой холбоотой өөрийн мэдлэгээ тухайн дүн шинжилгээнд хувь нэмэр болгож оруулсан бол баярлах байсан гэж мэдэгдсэн.

Мэдээллийг ил болгох ба хэлэлцүүлэх

68. МИНИС нь УННМТ-ний төслийг Банкнаас хянаж, олон нийтэд ил болгосны дараа олон нийтээр хэлэлцүүлнэ гэж Хороонд мэдэгдсэн. МИНИС нь техникийн болон техникийн бус хураангуйг бэлтгэж байгаа бөгөөд тэдгээрийг мөн нийтэд ил болгоно.

69. Усны дата мэдээлэл нь үндэсний аюулгүй байдлын асуудал учраас Нууцын тухай хуулинд зааснаар мэдээллийн хүртээмж Монгол Улсад хязгаарлагдмал байдаг гэж Засгийн газрын төлөөлөл Хороонд мэдэгдсэн. Удирдлага нь өөрийн Хариундаа баримт бичгүүдийг ил болгохыг Засгийн газарт уриалсан гэж дурдсан. Удирдлага нь тус Банкнаас санхүүжүүлж, нийтэд ил болгосон 13 судалгааны гурвынх нь жагсаалтыг ирүүлсэн бөгөөд бүс нутгийн УННМТ болох гурван нэмэлт судалгааг Банкны бодлогын дагуу Банкнаас төслүүдийг нь баталсны дараа нийтэд ил болгоно гэж тайлбарласан. Монгол Улсын Засгийн газар нь бас нэг судалгааг нийтэд ил болгох боломжтой эсэхийг одоогоор хянаж судалж байгаа аж.

70. Усны судалгаануудыг нийтэд ил болгох боломжгүй гэх хуулийн тайлбартай санал нийлэхгүй байгаа бөгөөд хүн амын эрүүл мэнд болон сайн сайхан байдалтай холбоотой аливаа мэдээллийг нууцлалын зэрэгт оруулах ёсгүй гэж үзэж байгаагаа Өргөдөл гаргагчид Хороонд мэдэгдсэн. Тэд орон нутгийн хүн амд хангалттай ус байгаа эсэхийг мэдэх эрхтэй гэж үзэж буй юм.

71. Усны дата мэдээлэл авах хүсэлт гаргахад хүсэлт гаргагчдыг хариуцах яаманд шилжүүлдэг бөгөөд яам нь тухайн судалгаа, датаг яамныхаа байранд үзэх зөвшөөрлийг мэргэжилтнүүдэд өгч болдог гэж МИНИС Хороонд дурдсан. Түүнтэй адилаар Алтайн-Өвөр говийн бүсийн СГЗ нь Төслөөс санхүүжүүлж буй мониторингийн цэгийн датаг Даланзад дахь оффисоос авч үзэх боломжтой гэж мэдэгдсэн. Гэтэл нутгийн иргэд нь датаг ингэж авах боломжтой талаар мэдэхгүй гэж мэдэгдсэн. Удирдлага нь мониторингийн цэгүүдээс авсан чухал датаг онлайнар ил болгоно гэж Хороонд мэдэгдсэн.

СГЗ-д болон СГЗӨ-үүдийн чадавх ба мониторингийн цэгүүд

72. МИНИС төслөөс СГЗ болон СГЗӨ-ийг цалин, сургалт, захиргааны болон уулзалтуудын зардлыг санхүүжүүлж, дэмжсэн нь чухал ач холбогдолтой байсан гэж Хороонд мэдэгдсэн. Гэсэн хэдий ч СГЗ болон СГЗӨ Төслийн санхүүжилт дууссаны дараа ажлаа тогтвортой үргэлжлүүлэх чадвартай байх эсэх нь санаа зовних асуудал болоод байгааг Хороонд дуулгасан.

73. МИНИС төслөөс хэмжих төхөөрөмж бүхий 119 цооногийг санхүүжүүлснээр томоохон хувь нэмэр оруулсан гэж бүхий л оролцогч талууд санал нэгтгэйгээр Хороонд мэдэгдсэн. Эдгээр цооногууд нь 2016 оны сүүл болоод 2017 оны эхээр ашиглалтанд орсон гэж Хороонд мэдэгдсэн. Эдгээр нь гүний усны түвшин, хэм, даралт болон чанарт хэмжилт хийдэг ба датаг СГЗ-ны ажилчид хэмжилтийн цэгүүдээс цуглуулж авдаг байна. Хэдэн улирлын дата бүрэлдсэн боловч чиг хандлагын талаарх найдвартай дата нь зөвхөн урт

хугацаанд бүрэлдэх юм. Урт хугацааны чиг хандлагын шинжилгээ хийхэд таван жилийн хугацаа шаардлагатай гэх санааг СГЗ хэлсэн.

74. Датаг хэмжих нь уурхай бүрээр усны хэрэглээг тогтоох боломжийг СГЗ-д бүрдүүлсэн бөгөөд ийм боломж 2016 оноос өмнө байгаагүй гэж Хороонд мэдэгдсэн. Уурхайнуудад усны төлбөр ногдуулахад уг датаг ашиглаж байна. Өдөрт 100м³ -ээс дээш хэрэглээтэй усны хэрэглэгчдэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зөвшөөрөл олгодог гэж Хороо ойлгож байна. СГЗ нь өдрийн хэрэглээ нь зөвхөн 50-100м³ -т хэлбэлзэх усны хэрэглэгчдэд зөвшөөрөл олгох эрхтэй тул уул уурхайн компаниудад усны зөвшөөрөл олгох шийдвэр нь тэдний чиг үүргээс гадуур байдаг гэж Хороонд мэдэгдсэн. Түүнчлэн, Алтай-Өвөр говийн СГЗ нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш ямар нэг усны зөвшөөрөл олгоогүй гэж Хороонд мэдэгдсэн.

Е.3. Хорооны хяналт

МИНИС төслийн үйл ажиллагаа болон болзошгүй хор уршгийн хоорондох холбоо

75. Удирдлага нь өөрийн өгсөн Хариундаа Өргөдлүүдэд дурдагдсан болзошгүй хор уршиг нь МИНИС төслийн санхүүжүүлж буй судалгаа болон чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанаас үүдэх боломжгүй гэж тогтоов. Удирдлага нь МИНИС төслийн хүрээнд судалж буй санал болгосон хөрөнгө оруулалтын барилгын ажлыг санхүүжүүлэхэд тус Банк оролцоогүй бөгөөд тэдгээрийг санхүүжүүлэх шийдвэр эсхүл амлалт өгөөгүйн дээр санхүүжүүлэх ямар нэг хүсэлт хүлээн аваагүй гэж мэдэгдсэн. Мэдээлэлд суурилсан бодит (объектив) шийдвэр гаргахад тус болох суурь мэдээллийг бүрдүүлэх зорилготойгоор Төслөөс санхүүжүүлж буй судалгаанууд болоод тэдгээрийг Монгол Улсын Засгийн газар шийдвэр гаргахдаа хэрхэн ашиглах вэ гэдэг нь хоёр өөр асуудал учир ялгаж, салган ойлгох нь зүйтэй хэмээн Удирдлага үзэж байна.

76. Удирдлага нь “ХНҮ нь Багануурын уурхайн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон Монгол Улсын хуулийн дагуу 2018 оны эцэст хийхээр төлөвлөсөн түүний БОННҮ-г шинэчлэн боловсруулах мэдээллээр хангана” гэж тайлбарлаж байна. ХНҮ-г эцэслэн боловсруулмагц Монгол Улсын Засгийн газар “ДЦС-ыг хөгжүүлэхтэй холбоотой мэдээллийг анхааралдаа авах боломжтой болно” хэмээн Удирдлага тэмдэглэсэн болно.²⁶

77. Дээр дурдсанчлан Төсөл нь Байгаль орчны А ангилалд хамаарна. ОР 4.01-ийн хэсэг 8(а)-д заасанчлан “мэдрэг, олон төрлийн болоод урьд өмнө гарч байгаагүй онц сөрөг нөлөөг байгаль орчинд үзүүлэхүйц бол тухайн төслийг Ангилал А-д хамааруулна.” Төслийн үнэлгээний баримт бичигт Удирдлага нь төсөл хэрэгжүүлэх үе шатан дахь болзошгүй хор уршиг болон МИНИС төслөөс санхүүжүүлэх судалгаа, чадавхыг бэхжүүлэх ажлын хооронд холбоо байгааг хүлээн зөвшөөрч²⁷, “нэн чухал/нэн чухал бус онгон байгаль болон биологийн олон янз байдал, онгон байгалийг хэсэгчлэх, зэрлэг ан амьтдын нүүдлийн зам хаагдах, гадаргын ургамал устах, газар доройтох, гүний ус бохирдох ба шавхагдах, дуу чимээ гарах болон агаар бохирдох, орон нутгийн иргэд эсхүл малчдад нийгмийн болон соёлын сарнил үүсэх гэх зэрэг байгаль орчны болон нийгмийн дундаас онц их нөлөөлөл” гарч болзошгүйг дурдсан байна²⁸.

²⁶ Удирдлагын хариу, х. 9, хэсэг. 41.

²⁷ Төслийн үнэлгээний баримт бичиг, 2011 оны 4-р сарын 7, х. 52, хэсэг. 196.

²⁸ Дээрхтэй адил, х. 51, хэсэг. 195

78. Дэд бүтцийн барилга эсхүл ашиглалттай холбоотой шийдвэр гаргахад мэдээллээр хангах Банкнаас санхүүжүүлж буй төслийн үйл ажиллагааг тус Банк дэд бүтцийн хөрөнгө оруулалтад өөрөө оролцохоос үл шалтгаалан Банкнаас стандарт хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл үе шаттай адилаар авч үзэх үүрэгтэй гэж Хороо тодотгож буй юм. Ийм төслийн үйл ажиллагаа нь Банкны холбогдох бодлого, журмуудын дагуу хэргэжих бөгөөд ижил түвшний хариуцлагын стандартыг мөрдөнө.

79. Хороо нь ХНУ болон ТЭЗҮ нь Багануурын уурхайн өргөтгөлийн техникийн дизайн болон нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгтэй мэдээллээр хангах болно гэж ойлгож байна. УННМТ нь Алтайн-Өвөр говийн бүс дэх усны нөөцийг хуваарилах шийдвэр гаргахад мэдээллээр хангах юм. Тиймээс эдгээр судалгаа эсхүл хэлэлцүүлгийн үйл явцад гарах аливаа дутагдал нь Банкны бодлого, журмыг зөрчсөнтэй холбоотой хор уршигт хүргэж болно гэж Хороо үзэж байна. Төслийн хүрээнд санхүүжүүлж буй судалгаанууд болоод чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь Хорооны хяналтын чиг үүрэгт хамаарах бөгөөд тэдгээр нь ирээдүйн хөрөнгө оруулалт, нэн чухал усны нөөцийн менежментэнд бэлтгэх алхмуудыг төлөөлж буй тул Өргөдлүүд нь хяналт шалгалт явуулах шаардлагыг хангаж байна гэж Хороо дүгнэв.

Багануурын уурхайн өргөтгөлийн үнэлгээ

80. ХНУ нь одоо байгаа Багануурын уурхай, уурхайн боломжит өргөтгөл, ДЦС-ын боломжит бүтээн байгуулалт болон ашиглалт, газар зүйн болон сэдвийн хувьд тус судалгааны хамрах хүрээнд багтах бусад олон дарамт үзүүлэх хүчин зүйлсийн хуримтлагдах нөлөөллийг үнэлнэ гэж Хороонд мэдэгдсэн.

81. Хороо нь ХНУ-ний АД-т анхан шатны үнэлгээ хийсэн. Анхны ХНУ нь зөвхөн Багануур дүүргийн нутаг дэвсгэр дотор багтах нөлөөллийг үнэлэх нөлөөллийн бүс тогтоосон байсан бол шинэчилсэн ХНУ-ний төсөлд хамаарал бүхий барилга байгууламжууд болон холбогдох хуримтлагдах нөлөөллүүдтэй уях байдлаар судалгааны газар зүйн хамрах хүрээг тогтоосон байна. Үүнд Хэрлэн голын сав газрын усны нөөц болон уурхайгаас олборлох нүүрсний гол хэрэглэгчид болох дулааны цахилгаан станцын орчмын газарт үзүүлэх нөлөөллүүдийг авч үзэхийг албадсан байна. Түүнчлэн АД-т Өргөдөл гаргагчдын дэвшүүлсэн сэдэв болох уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хамруулсан байна. Анхны ХНУ нь түүнд хамаарах хугацааг 2025 оноор хязгаарлах саналтай байсан бол шинэчилсэн АД-т хугацааны хамрах хүрээг санал болгож буй аж үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах нийт хугацаатай уялдуулах, тооцоолж буй байгаль орчны өөрчлөлтийг тусгахаар болсон байна.

82. Эрүүл мэндийн нөлөөлөл болон агаарын бохирдлын хувьд Удирдлага нь өөрийн өгсөн Хариундаа ХНУ-ний хүрээнд уурхайн өргөтгөлийн үр дүнд нүүрсийг нэмэлтээр боловсруулах, тээвэрлэх, шатаах эсхүл хий гаргаж авахтай холбоотой байгаль орчны болон нийгмийн нөлөөллийг үнэлнэ гэж дурдсан байна. Удирдлага нь ДЦС-ын агаарын бохирдолд үзүүлэх нөлөөллийг ДЦС-ын БОННУ-нд авч үзэх нь зүйтэй боловч ДЦС-аас ялгарах болзошгүй бохирдлыг агаарын урсгалаар хүлээн авах асуудлыг ХНУ-ний хүрээнд байгаль орчны эрсдэлүүдийн нэгээр тооцож судлана гэж онцолж буй юм. Удирдлага нь мөн 2016 оны ТЭЗҮ-ний хүрээнд Багануурын нүүрсний цацраг идэвхийг 2012 болон 2013 онд хянаж

үзсэн бөгөөд Багануурын уурхайн үндсэн нүүрсэн дэхь цацрагийн хэмжээ хэвийн болон бага түвшинд гарсан гэж тайлбарлаж буй.

83. Уурхайн өргөтгөл болон ДЦС-тай холбоотой нийгмийн нөлөөллийн хувьд ХНҮ-ний хүрээнд Өргөдөл гаргагчдын тавьж буй ЖСХ гэх зэрэг ажиллах хүч шилжин ирэх нөлөөллийг авч үзнэ гэж Удирдлага мэдэгдлээ. Түүнчлэн Удирдлага нь 2018 оны 1-р сард уурхайн өргөтгөл болон ДЦС-тай холбоотой нийгмийн асуудлуудыг тусгайлан авч үзэхээр баг томилон ажиллуулсан гэж тайлбарлаж байна. Томилгоот баг нь уурхайн өргөтгөлөөс үүдэж болзошгүй нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлууд байхын зэрэгцээ орон нутгийн иргэдээс илүү их мэдээлэл шаардагдаж байгааг тодорхойлсон. Хороо нь нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг ХНҮ-ний хүрээнд үнэлнэ гэж ойлгож байна.

84. ХНҮ-ний чанарыг сайжруулах үүднээс Удирдлага нь зөвлөхүүдэд тус үнэлгээг бичихтэй холбоотой удирдамжаар ханган идэвхитэй ажиллаж буйг Хороонд томилгоот ажлынх нь үед мэдэгдсэн. Хороо нь судалгааны чанарыг зөвхөн эцсийн төсөл нь бэлэн болсны дараа үнэлэх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч буй боловч Удирдлага нь ХНҮ-г хүлээн авахаасаа өмнө Банкны шаардлагыг хангуулахаар тууштай ажиллаж байгааг нь онцолж байна.

85. Банкны бодлогын шаардлагын дагуу ХНҮ-ний АД-ыг олон нийтийн өргөн оролцоотой хэлэлцүүлэх шаардлагатай. Түүнчлэн тус бодлогын дагуу аливаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаасаа өмнө оролцогч талуудад тайлангийн эцсийн төслийг судалж, санал өгөх хангалттай хугацаа олгосон байх шаардлагатай юм. Түүнчлэн ХНҮ-нд бүх оролцогч талуудыг тодорхойлох, тодорхойлсон оролцогч талуудыг урих, хэвлэл мэдээллээр нийтлэх, МИНИС-ийн хэлэлцүүлгийн төвлөрсөн цахим хуудас дээр хангалттай хугацаанд ил болгох замаар хэлэлцүүлгийг түгээх шаардлагатай юм.

86. Удирдлага нь Банкны бодлогын хүрээнд хэлэлцүүлгийг сайн туршлагын дагуу өрнүүлэх үүднээс Зээлдэгчтэй хамтран ажиллана гэж өөрийн өгсөн Хариундаа дурдсан.²⁹ Удирдлага нь ТУН-ид хэлэлцүүлэг явуулах асуудлаар зөвлөгөө өгч ажиллаж байгааг Хороо тэмдэглэж байна.

Алтайн-Өвөр говийн бүсийн усны менежмент

87. Хороо нь ус багатай говийн бүсэд усны боломжит нөөцийн талаар ойлголттой болох, тогтвортой байдлаар усны нөөцийн хуваарилалт хийх зорилгоор СГЗ болон СГЗӨ-г байгуулах болоод УННМТ-г боловсруулах нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байна. УННМТ-г боловсруулах үе шатанд явж байгаа бөгөөд түүний хүрээнд Өргөдөл гаргагчдын тавьсан байгаль орчин болон нийгмийн болзошгүй сөрөг нөлөөллийг судална гэж Хороо ойлгож байна.³⁰

88. Хороо нь УННМТ-ний АД-ыг хянаж үзсэн бөгөөд энэхүү Төслийн гол зорилт нь уг бүс нутаг дахь хүн амыг тогтвортой усны нөөцтэй байлгах нөхцөлөөр хангах гэдгийг тэмдэглэж байна. АД нь ерөнхий боловч түүний хавсралтад илүү дэлгэрэнгүйг оруулсан байна. Хүн ам усыг уламжлалт үнэт зүйлсийнхээ хүрээнд багтааж үздэгийн ач холбогдлыг

²⁹ Удирдлагын хариу, х. 10, хэсэг. 46.

³⁰ Дээрхтэй адил. х. 13, хэсэг. 57.

Хороо тэмдэглэж байна. АД-т экосистемийн үйлчилгээ гэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгаагүй боловч Удирдлагын үзэж буйгаар баримт бичгийн төслүүдийг дахин хянаж үзэх процессын хүрээнд тэдгээрийг авч үзэж буй юм. Холбогдох суурь мэдээлэл олж авах, дотоодын аргачлал болон олон улсын практикийн хооронд зөрүү байдаг зэргийн бэрхшээл байгааг Хороо тэмдэглэж байна.

89. Хороо нь Алтайн-Өвөр говийн УННМТ-ний хэлэлцүүлгийн төлөвлөгөөний төслийг мөн хянаж үзсэн. Уг төлөвлөгөөний дагуу 17 суманд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах юм.³¹ Түүнд хүн амыг аюулгүй, хүртээмжтэй усаар хангах нь уг сав газрын хамгийн чухал асуудал, тиймээс нутгийн удирдлага, сав газрын мэргэжилтнүүд, сав газрын зөвлөлийн гишүүд болон иргэд олон нийтийн хэлэлцүүлэгт оролцоно гэж дурдсан байсан. Удирдлага нь хэлэлцүүлгийг Банкны шаардлагад нийцүүлэн явуулна гэж баталгаажуулсан. УННМТ-ний техникийн болон техникийн бус хураангуйг уулзалт болохоос хоёр долоо хоногийн өмнө оролцогч талуудад тарааж, саналын хүснэгтийг уулзалтанд зориулан бэлтгэнэ гэж Хороо ойлгож байгаа. Тиймээс Өргөдөл гаргагчид болон бусад талууд УННМТ-ний чанартай холбоотой санаа зовниж буй асуудлуудаа уг хэлэлцүүлгийн үеэр илэрхийлэх боломжтой гэж Хороо үзэж байна.

Г. Зөвлөмж

90. Хороо нь 1999 оны Тайлбарын 5-р хэсэгт “Хороо нь Банкны зөрчилгүй даган мөрдөж буй эсхүл дагаж мөрдөх гэсэн зорилгын нотолгоо хангалттай эсэхийг өөрөө бие даан шийдвэрлэж, уг дүгнэлтээ Захирлуудын Зөвлөлд өргөн барих тайланд тусгана” гэж заасныг харгалзан үзэж өөрийн зөвлөмжийг гаргаж буй болно.

91. Хорооны хяналтын хэсэг Е.3-т дээр дурдсаны дагуу Удирдлагын өнөөг хүртэл гаргасан хүчин чармайлт, өгсөн амлалт нь холбогдох үнэлгээ, хэлэлцүүлгийг Банкны бодлого, журмын дагуу явуулах нөхцөлөөр хангахад чигэлсэн Удирдлагын зорилгыг нотолж буй хэмээн Хороо үзэж байна. Тиймээс, Хороо нь хяналт шалгалт явуулахыг зөвлөхгүй байна.

92. Уг зөвлөмжийг гаргаснаар шинэ нотолгоо буй болсон эсхүл энэхүү Өргөдөл гаргах үед олж илрүүлээгүй байсан шинэ нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор ирээдүйд Хяналт шалгалт явуулах Өргөдөл дахин гаргах боломжийг үгүйсгэхгүй.

93. Хэрэв Захирлын Зөвлөл энэхүү зөвлөмжтэй санал нэгдвэл Хороо нь Өргөдөл гаргагчдад тийнхүү мэдэгдэнэ.

³¹ Сум нь Монгол Улсын хоёр дахь захиргааны хоёр дахь шатны дэд нэгж бөгөөд дүүрэгтэй тэнцэнэ.